



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 03 өдөр

Дугаар A/191

Мөрөн сум

Санхүүгийн хяналт, дотоод аудитын
албаны бүтэц, орон тоог шинэчлэн
батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.12, 69 дүгээр зүйлийн 69.1, Засгийн газрын 2019 оны 275, 2021 оны 377 дугаар тогтоол, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын 2021 оны ХӨА-2021/15-21ШТА-ГА дугаар гүйцэтгэлийн аудитын дүгнэлтийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Засгийн газрын шийдвэрийн дагуу аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэрэгжүүлэгч агентлаг Сандхүүгийн хяналт, аудитын албыг Сандхүүгийн хяналт, дотоод аудитын алба болгон өөрчилж, тус газрын бүтэц орон тоог хавсралтаар баталсугай.

2. Тус байгууллагын батлагдсан орон тоотой уялдуулан холбогдох төсвийг хянаж, санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэж ажиллахыг Аймгийн Засаг даргын Тамгын газрын дэргэдэх Сандхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Базарт)-д даалгасугай.

3. Бүтэц, орон тоог баталсантай холбогдуулан албан тушаалын тодорхойлолтыг ажилтан, албан хаагчдын ажлын чиг үүргийн дагуу зохих аргачлалын дагуу боловсруулж, албан тушаалын чиг үүргийг нарийвчлан тогтоож, удирдлага, арга зүйгээр хангаж ажиллахыг Сандхүүгийн хяналт, дотоод аудитын албаны даргын үүргийг түр орон гүйцэтгэгч (Г.Мөнхтулга)-д үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (П.Ариунбат)-т даалгасугай.

5. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан “Сандхүүгийн хяналт, аудитын албаны бүтэц орон тоог батлах тухай” аймгийн Засаг даргын 2020 оны 02 сарын 11-ний өдрийн Б/12 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

Ш.ИДЭРБАЯСГАЛАН



Аймгийн Засаг даргын 2022 оны

06 дүгээр сарын 03-ны өдрийн
A/191 дугаар захирамжийн хавсралт

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН
АЛБАНЫ БҮТЭЦ ОРОН ТОО

№	Албан тушаал	Орон тоо	Албан тушаалын ангилаал зэрэглэл
1	Албаны дарга	1	ТЗ-10
2	Ахлах дотоод аудитор	1	ТЗ-7
3	Дотоод аудитор/ улсын ахлах байцаагчийн эрхтэй/	2	ТЗ-7
4	Дотоод аудитор	5	ТЗ-6
5	Дотоод ажил, архив бичиг хэрэг хариуцсан ажилтан	1	ТҮ-7
6	Жолооч	1	ТҮ-3
	Нийт	11	